

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 10 дугаар сарын 31-ний
өдөр

Улаанбаатар хот

Дугаар 336 ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ

Баяжуулсан хүнсний тухай хуулийн 5.2 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2018 оны 30 дугаар тогтоолын 1.1 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. “Албан журмаар баяжуулах хүнсний жагсаалт”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Албан журмаар баяжуулах хүнсний төрөл тус бүрээр бүтээгдэхүүний стандарт боловсруулж 2019 оны II улиралд багтаан батлуулах, БГ-055 ангиллын буудайн гурилыг баяжуулах бэлтгэл ажлыг үе шаттайгаар зохион байгуулахыг Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Б.Батзориг нарт тус тус даалгасугай.
3. Албан журмаар хүнс баяжуулах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Н.Цагаанхүү)-т даалгасугай.
4. Энэ тогтоолыг Баяжуулсан хүнсний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн мөрдсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ


Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн

үйлдвэрийн сайд

Б.БАТЗОРИГ

Эрүүл мэндийн сайд

Д.САРАНГЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Буудайн баяжуулсан гурил.
Техникийн ерөнхий шаардлага



Албан хэвлэл

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УЛААНБААТАР ХОТ

2019 он

Өмнөх үг

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) нь Олон улсын стандартчиллын байгууллагын (ОУСБ) гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран үндэсний стандартчиллын бодлогыг хэрэгжүүлэх ажил эрхэлдэг.

Стандартын төсөл боловсруулах ажлыг салбарын стандартчиллын техникийн хороо (ТХ), дэд хороо (ДХ) эрхлэн гүйцэтгэдэг бөгөөд техникийн хорооны хурлаар хэлэлцэж, 75%-иас доошгүй хувийн саналаар дэмжиж, зөвшилцсөн төслийг Стандарт, хэмжил зүйн газрын даргын тушаалаар баталснаар хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хоол судлалын албаны ЭША Н.Болормаа, ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн газрын Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Бямбатогтох, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хоол судлалын албаны дарга Ж.Батжаргал нар боловсруулж, СХЗГ-ын ахлах мэргэжилтэн Д.Даваасүрэн "MNS 1-2:2006, Монгол улсын стандартчиллын тогтолцоо. 2-р хэсэг: Стандартын бүтэц ба боловсруулах дүрэм" стандартад нийцүүлсэн.

Ургамлын гаралтай хүнсний стандартчиллын дэд хороогоор хэлэлцэн, зөвшилцсөн болно.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Улаанбаатар Ш/Х – 48

Утас 266754, 263860 Факс (976-11) 458032

web: www.masm.gov.mn, www.estandard.gov.mn,

E-mail: standardinform@masm.gov.mn

© СХЗГ, 2019

"Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай" Монгол Улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-д байна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 67.060

Буудайн баяжуулсан гурил. Техникийн ерөнхий шаардлага
Fortified wheat flour. General technical requirements

СТАНДАРТЫН
БОЛОВСРУУЛАГЧИД
ОЛГОСОН ХУВЬ

MNS 6812 :2019

MNS 5156

2003-ЫН ӨРӨНД

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн С/69 дүгээр тушаалаар батлав.

Энэхүү стандарт нь 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь баяжуулагч бэлдмэлээр баяжуулсан буудайн (цаашид баяжуулсан гурил гэх) БГ-055, БГ-075, БГ-085, БГТ-075 ангиллын гурилыг үйлдвэрлэх, шалгаж хүлээн авах, савлах, шошголох, хадгалах, тээвэрлэхэд хамаарна.

2 Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах олон улсын болон үндэсний стандартыг эш татан хэрэглэсэн болно. Эш татсан эдгээр стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн албан ёсны эхийг баримтална. Үүнд:
MNS 0244:2009, Буудайн гурил. Техникийн ерөнхий шаардлага;
CAC 152:1995, Буудайн гурил;
CXS 193-1995, Хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах бохирдуулагч ба хорт бодис. Ерөнхий стандарт (Rev. 2009; Amend. 2019);
MNS CAC/RCP 1:2003, Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим (олон улсын зөвлөмж);
MNS 4504:2008, Хүнсний бүтээгдэхүүн дэх хүнд металын үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ;
MNS 5868:2008, Хүнсний бүтээгдэхүүн дэх пестицидын үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ;
MNS 5649:2006, Үр тариа, гурил, будаа тээвэрлэлт. Ангилал. Тээвэрлэлтийн нөхцөл. Ерөнхий шаардлага;
MNS 6811:2019, Буудайн гурилыг баяжуулагч бэлдмэл. Техникийн ерөнхий шаардлага;
MNS 6648:2016, Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага;
CAC/GL 09-1987, Хүнсийг шимт бодисоор баяжуулах ерөнхий зарчим.

3 Нэр томъёо, тодорхойлолт

3.1

баяжуулсан гурил

буудайн гурилын шимт чанарыг сайжруулах зорилгоор баяжуулагч бэлдмэлийг үйлдвэрийн аргаар нэмсэн бүтээгдэхүүн

3.2

баяжуулагч бэлдмэл

хүнсийг үйлдвэрийн аргаар баяжуулахад хэрэглэх аминдэм, эрдэс бодис, эсхүл тэдгээрийн холимог

4 Техникийн шаардлага

4.1 Баяжуулсан гурилыг "MNS CAC RCP 1 : 2003, Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим (олон улсын зөвлөмж)" стандартын шаардлага хангасан үйлдвэрт аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлан батлагдсан технологийн зааврын дагуу үйлдвэрлэнэ.

4.2 Баяжуулсан гурилыг "MNS 0244 : 2009, Буудайн гурил. Техникийн ерөнхий шаардлага" стандартын шаардлага хангасан түүхий эдээр үйлдвэрлэнэ.

4.3 Өргөн хэрэглээний болон талхны зориулалтын баяжуулсан гурилын чанар нь мэдрэхүйн эрхтэний үнэлгээгээр 1, физик химийн үзүүлэлтээр 2, аюулгүй байдлын үзүүлэлтээр 3 дугаар хүснэгтэд заасан шаардлагыг тус тус хангасан байна.

1-р хүснэгт - Баяжуулсан гурилын мэдрэхүйн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлт	Шинж чанар, ангиллаар	
		БГ-055	БГ-075, БГ-085, БГТ-075
1.	Өнгө	Цайвар шаргал туяатай цагаан	Шаравтар туяатай цагаан
2.	Үнэр	Буудайн гурилын хэвийн үнэртэй, хөгцний буюу исгэлэн үнэргүй байна. Баяжуулагч бэлдмэлийн сулавтар үнэртэй байж болно.	
3.	Амт	Буудайн гурилын хэвийн амттай байна. Исгэлэн гашуун, чихэрлэг амтгүй байна.	
4.	Эрдэс хольц	Захлахад элсэрхэг, хатуу хольц мэдрэгдэхгүй.	

2-р хүснэгт - Баяжуулсан гурилын физик химийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ			
			БГ-055	БГ-075	БГ-085	БГТ-075
1.	Чийг, ихгүй	%	15,5	15,5	15,5	15,0
2.	Үнслэг, ихгүй	%	0,55	0,75	0,85	0,75
3.	Ширхэгжилт, ихгүй Капрон шигшүүрийн дугаар	%	5,0	3,0	3,0	2,0
		№	43	38	38	39
		микрон	165	200	200	200
4.	Нойтон цавуулаг, багагүй	%	23,0	26,0	26,0	30,0
5.	Цавуулгийн чанар, ИДК-ийн заалт, бүлгээр, доошгүй	нэгж	20-100 II	20-100 II	20-100 II	20-75 II
6.	Хүчиллэг, ихгүй	°Н	3,5	3,8	4,0	4,0
7.	Аминдэм, эрдсийн агуулга		В ₁ /тиамин/			
			1,3 - 1,5			
			В ₂ /рибофлавин/			
			2,0 - 2,3			
			В ₃ /ниацин/			
			6,7 - 7,7			
			В ₉ /фолийн хүчил/			
1,3 - 1,5						
Төмөр						
30,0 - 34,5						
Цайр						
18,7 - 21,5						
D ₃ холекальциферол						
0,0250 - 0,0288						

3-р хүснэгт - Баяжуулсан гурилын эрүүл ахуй, аюулгүйн үзүүлэлт

Үзүүлэлт		Зөвшөөрөгдөх хэмжээ
Хортон шавж, өндөг, авгалдай		Илрэх ёсгүй
Төмний савханцрын тоо, 1 г гурилд, ихгүй		200
Гэдэсний бүлгийн эмгэг төрүүлэгч нян		Илрэх ёсгүй
Хүнд метал, мг/кг, ихгүй	Кадьми	0,2
	Хар тугалга	0,2
Пестицидийн үлдэгдэл, мг/кг, ихгүй		MNS 5868:2008 стандартад заасан хэмжээгээр
Микотоксин "Зеаролонон", мг/кг, ихгүй		1,0
Цацрагийн бохирдол		Илрэх ёсгүй

5 Шалгаж хүлээн авах

Баяжуулсан гурилыг дараах стандартын дагуу шалгаж хүлээн авна. Үүнд:

- MNS 245:1989, Гурил ба хивээг шинжлэх арга;
 MNS 5157, Хүнсний нэмэлт. Аминдэм-эрдсийн "КАР комплекс №1" нэмэлтээр баяжуулсан гурилыг шинжлэх арга;
 MNS ISO 21528-2:2016, Хүнс ба малын тэжээлийн Микробиологи, Гэдэсний бүлгийн бактерийг илрүүлэх болон тоолох аргууд. 2-р хэсэг: Колони тоолох арга;
 MNS ISO 7937:2000, Хүнс, малын хоол тэжээлийн микробиологи. Клостридум перфрингенсийн тоог тогтоох нийтлэг арга. Колони тоолох арга;
 MNS 4499:97, Хүнсний бүтээгдэхүүнд кадмийн агуулгыг тодорхойлох атом шингээлтийн спектрометрийн арга;
 MNS 4496:97, Хүнсний бүтээгдэхүүнд хар тугалгын агуулгыг тодорхойлох атом шингээлтийн спектрометрийн арга;
 MNS 4832:99, Хүнсний бүтээгдэхүүнд фосфор органик пестицид тодорхойлох нимгэн үет хроматографийн арга;
 MNS 4833:99, Хүнсний бүтээгдэхүүнд хлор органик пестицид тодорхойлох нимгэн үет хроматографийн арга;
 MNS 5691:2006, Буудай, үр тариа, түүгээр хийсэн бүтээгдэхүүнд микотоксин зеаралегогыг тодорхойлох нимгэн үет хроматографийн арга;
 MNS 5069:2000, Үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс зэрэг ургамлын гаралтай бүтээгдэхүүнд цацраг идэвхт элемент тодорхойлох гаммаспектрометрийн арга.


6 Савлалт, шошгололт

- 6.1 Баяжуулсан гурилыг зориулалтаар ангилан хүнсний зориулалтын, эрүүл ахуйн шаардлага хангасан цаасан уут, шуудайнд 50 кг хүртэл жинтэйгээр савлаж, амсрыг битүүмжилнэ.
 6.2 Савласан баяжуулсан гурилын жингийн хэлбэлзэл $\pm 1,0$ %-аас ихгүй байна.
 6.3 Баяжуулсан гурил нь "MNS 6648 : 2016, Хүнсний бүтээгдэхүүний сав, боодлын шошгололтод тавих шаардлага" стандартын шаардлагыг хангасан шошготой байна.
 6.4 Бүтээгдэхүүний шошго дээр эрх бүхий байгууллага баталсан, баяжуулсан болохыг илэрхийлэх тэмдэг, тэмдэглэгээ тавина.

7 Хадгалалт, тээвэрлэлт


- 7.1 Баяжуулсан гурилыг агаарын солилцоо сайтай, 15°C -ээс ихгүй температуртай, агаарын харьцангуй чийглэг нь 60 %-аас ихгүй, хортон, шавж, мэрэгчээр бохирдоогүй, гадны элдэв өвөрмөц үнэргүй, тоос шороо, чийгээс бүрэн хамгаалсан зориулалтын агуулахад тавиур дээр эгнүүлэн өрж хадгална.
 7.2 Баяжуулсан гурилыг энэ стандартын 7.1-д заасан шаардлага хангасан нөхцөлд үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар хүртэл хугацаагаар хадгална.
 7.3 Баяжуулсан гурилыг ачих, буулгах үед хур тунадас, шороо, тоосноос хамгаална.
 7.4 Баяжуулсан гурилыг "MNS CAC RCP 1 : 2003, Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим (олон улсын зөвлөмж)" стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

ТӨГСӨВ.



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Буудайн гурилыг баяжуулагч бэлдмэл.
Техникийн ерөнхий шаардлага



Албан хэвлэл

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УЛААНБААТАР ХОТ

2019 он

Өмнөх үг

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) нь Олон улсын стандартчиллын байгууллагын (ОУСБ) гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран үндэсний стандартчиллын бодлогыг хэрэгжүүлэх ажил эрхэлдэг.

Стандартын төсөл боловсруулах ажлыг салбарын стандартчиллын техникийн хороо (ТХ), дэд хороо (ДХ) эрхлэн гүйцэтгэдэг бөгөөд техникийн хорооны хурлаар хэлэлцэж, 75%-иас доошгүй хувийн саналаар дэмжиж, зөвшилцсөн төслийг Стандарт, хэмжил зүйн газрын даргын тушаалаар баталснаар хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хоол судлалын албаны ЭША Н.Болормаа, ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн газрын Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Бямбатогтох, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хоол судлалын албаны дарга Ж.Батжаргал нар боловсруулж, СХЗГ-ын ахлах мэргэжилтэн Д.Даваасүрэн "MNS 1-2:2006, Монгол улсын стандартчиллын тогтолцоо. 2-р хэсэг: Стандартын бүтэц ба боловсруулах дүрэм" стандартад нийцүүлсэн.

Ургамлын гаралтай хүнсний стандартчиллын дэд хороогоор хэлэлцэн, зөвшилцсөн болно.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Улаанбаатар Ш/Х – 48

Утас 266754, 263860 Факс (976-11) 458032

web: www.masm.gov.mn, www.estandart.gov.mn,

E-mail: standardinform@masm.gov.mn

© СХЗГ, 2019

“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай” Монгол Улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-д байна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 67.220.20

СТАНДАРТЫН
БОЛОВСРУУЛАГЧИД
ОЛГОСОН ХУВЬ

Буудайн гурилыг баяжуулагч бэлдмэл. Техникийн ерөнхий шаардлага

MNS 6811 : 2019

Wheat flour premix. General technical requirements

MNS 5154 : 2002-ЫН
оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн С/69 дүгээр тушаалаар батлав.

Энэхүү стандарт нь 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь буудайн гурилыг баяжуулагч бэлдмэлийг импортлох, үйлдвэрт шалгаж хүлээн авах, хадгалах, тээвэрлэх, үйлдвэрлэлд хэрэглэхэд хамаарна.

2 Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах олон улсын болон үндэсний стандартыг эш татан хэрэглэсэн болно. Эш татсан эдгээр стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн албан ёсны эхийг баримтална. Үүнд:

- MNS 2738:79, B₁ (тиамин);
- ГОСТ 30178:1996, Fe (фумарат төмөр);
- MNS 4497:97, Zn (цайрын исэл);
- MNS 1839:73, Буудайн цардуул;
- ГФ-Х-585 хуудас, B₂ (рибофлавин);
- ГФ-Х-56 хуудас, B₃ (ниацин);
- ГФ-Х-13 хуудас, B₉ (фолийн хүчил);
- D₃ аминдэм (холекальциферол).

3 Нэр томьёо, тодорхойлолт

3.1

баяжуулагч бэлдмэл

хүнсний үйлдвэрийн аргаар баяжуулахад хэрэглэх аминдэм, эрдэс бодис, эсхүл тэдгээрийн холимог

4 Техникийн шаардлага

4.1 Баяжуулагч бэлдмэл нь мэдрэхүйн болон физик үзүүлэлтээр 1, химийн найрлагаар 2, аюулгүй байдлын үзүүлэлтээр 3 дугаар хүснэгтэд заасан шаардлагыг тус тус хангасан байна.

1-р хүснэгт - Баяжуулагч бэлдмэлийн мэдрэхүйн болон физик шинж чанар

Үзүүлэлт	Шинж чанар
Гадаад байдал	Гулгамтгай, нэг төрлийн нунтаг
Өнгө	Шаргал, бор шаргал, улаан хүрэн
Үнэр	Бэлдмэл орсон аминдэмийн өвөрмөц үнэртэй
Амт	Үл мэдэг төмрийн амттай
Чийг, %, ихгүй	4.0
Гадны хольц	Илрэх ёсгүй
Ширхэгжилт, үлдэц %, ихгүй	5 (капрон шигшүүрийн дугаар 29, 258 микрон)

2-р хүснэгт – Баяжуулагч бэлдмэлийн физик, химийн найрлага

Бичил тэжээл	Бэлдмэлд агуулагдах хэмжээ		Химийн нэгдэл
	доод	дээд	
Тиамин (В ₁), мг/г	5,85	7,48	Тиамин мононитрат
Рибофлавин (В ₂), мг/г	9,00	11,5	Рибофлавин
Ниацин (В ₃), мг/г	30,2	38,5	Ниацинамид
Фолийн хүчил (В ₉), мг/г	5,85	7,48	Фолийн хүчил
Төмөр, мг/г	135	173	Фумарат төмөр
Цайр, мг/г	84,2	108	Цайрын исэл
Д ₃ аминдэм, мг/г	0,114	0,146	Холекальциферол 100,000 ОУН/г
Дүүргэгч бодис			Буудайн цардуул

3-р хүснэгт – Баяжуулагч бэлдмэлийн аюулгүй байдлын үзүүлэлт

Үзүүлэлтийн нэр		Зөвшөөрөгдөх хэмжээ
Нянгийн ерөнхий тоо (дундсаг агаартан), 1 г-д, ихгүй		1000
Гэдэсний савханцрын бүлгийн нян (колиформ), 1 г-д, ихгүй		10
Алтлаг стафилакокк, 1 г-д		Илрэх ёсгүй
Сальмонелл, 25 г-д		Илрэх ёсгүй
Энтеробактер, 10 г-д		Илрэх ёсгүй
Хөрөнгөнцөр (yeast), 1 г-д, ихгүй		10
Мөөгөнцөр (moulds), 1г-д, ихгүй		100
Хүнд металл, мг/кг, ихгүй	Хар тугалга, Pb	2,0
	Кадьми, Cd	1,0
	Мөнгөн ус, Hg	0,1
	Хүнцэл, As	0,01

5 Шалгаж хүлээн авах

5.1 Нэг цувралын ижил жин, савлагаатай, нэг чанарын хяналтын гэрчилгээтэй баяжуулагч бэлдмэлээс шинжилгээнд 4 дүгээр хүснэгтэд заасан хэмжээгээр дээж авна.

4-р хүснэгт – Шинжилгээнд хамруулах дээжийн тоо

Цувралын хэмжээ, хайрцаг	Дээжийн тоо
2 – 15	2
16 – 25	3
26 – 50	5
51 – 150	8
≥ 151	13

5.2 Баяжуулагч бэлдмэлийн цуврал бүрээс 200 граммаас ихгүй хэмжээтэй дээж авч шинжилнэ.

5.3 Баяжуулагч бэлдмэлийн амт, үнэр, гадны хольцыг мэдрэхүйн аргаар тодорхойлно.

5.4 Баяжуулагч бэлдмэлийн чанарыг дараах стандартын дагуу тодорхойлно. Үүнд:

MNS ISO 4831:99, Колиформын тоог тоолох. Колони тоолох арга;

MNS ISO 4834:99, Гэдэсний бүлгийн савханцрын тоо;

MNS ISO 6888-1:2011, Хүнс ба малын тэжээлийн микробиологи. Сийвэн бүлэгнүүлэгч стафилококкын тоог тогтоох (*Staphylococcus aureus* болон бусад зүйл) 1-р хэсэг: Байрд Паркер агар хэрэглэх заавар;

- MNS ISO 6888-2:2011, Хүнс ба малын тэжээлийн микробиологи. Сийвэн бүлэгнүүлэгч стафилококкын тоог тогтоох (*Staphylococcus aureus* болон бусад зүйл) 2-р хэсэг: Туулайны цусны сийвэнтэй агаар хэрэглэх заавар;
- MNS ISO 6579:99, Микробиологи. Салмонелл илрүүлэх өрөнхий заавар;
- MNS 5686:2006, Хүнсний бүтээгдэхүүнд энтерококк тодорхойлох арга;
- MNS ISO 7954:95, 25 градус ургасан хөгц, мөөг, хөрөнгөнцөрийн колони тоолох арга;
- MNS 4496:97, Хүнсний бүтээгдэхүүнд хар тугалын агуулгыг тодорхойлох атом шингээлтийн спектрометрийн арга;
- MNS 4499:97, Хүнсний бүтээгдэхүүнд кадмийн агуулгыг тодорхойлох атом шингээлтийн спектрометрийн арга;
- MNS ISO 11212-1:2000, Цардуул ба түүгээр хийсэн бүтээгдэхүүн. Хүнд металл агууламж Хэсэг 1: Атом шингээлтийн спектрофотометрийн аргаар хүнцлийн агууламжийг тодорхойлох;
- MNS ISO 11212-2:2000, Цардуул ба түүгээр хийсэн бүтээгдэхүүн. Хүнд металл агууламж. Хэсэг 2: Атом шингээлтийн спектрофотометрийн аргаар мөнгөн усны агууламжийг тодорхойлох;
- MNS 5155:2002, Хүнсний нэмэлт. Амндэм-эрдсийн KAP Комплекс 1 нэмэлтийг шинжлэх арга;
- MNS 2134:2007, Үр тариа. Нөхцөлт цардуулын агуулгыг тодорхойлох арга.

6 Савлалт, хаяглалт

- 6.1 Баяжуулагч бэлдмэлийг ус, агаар нэвтрэхгүй, хүнсний зориулалтын уут, саванд сайтар битүүмжлэн савласан байна.
- 6.2 Баяжуулагч бэлдмэлийг 25 кг хүртэл хэмжээгээр савлана.
- 6.3 Баяжуулагч бэлдмэлийг савласан хайрцаг нь дараах мэдээлэл бүхий шошготой байна. Үүнд:
- Нэр
 - Хэрэглэх заавар
 - Цувралын дугаар
 - Үйлдвэрлэсэн огноо
 - Хадгалах / хэрэглэж дуусах хугацаа
 - Үйлдвэрлэгчийн нэр, хаяг
 - Үйлдвэрлэсэн орны нэр
 - Баяжуулагч бэлдмэлийн найрлага: 1 г бэлдмэлд агуулагдах амндэм, эрдсийн хэмжээг мг-аар илэрхийлж бичнэ.
 - Цэвэр жин
 - Хадгалах заавар, хадгалах нөхцөл
- 6.4 Баяжуулагч бэлдмэлийн цуврал бүрт дараах мэдээллийг агуулсан чанарын хяналтын гэрчилгээ (CoA-Certificate of Analysis) дагалдуулна. Үүнд:
- Гэрчилгээний дугаар
 - Шинжилгээ хийсэн огноо
 - Шимт бодисын найрлагыг тодорхойлсон шинжилгээний дүн
 - Нян болон хор судлалын үзүүлэлтийг тодорхойлсон шинжилгээний дүн
 - Хүнд металын үйлдэгдлийг тодорхойлсон шинжилгээний дүн
 - Цацрагийн бохирдол тодорхойлсон шинжилгээний дүн
 - Үйлдвэрлэгч орон болон байгууллагын нэр эсвэл дугаар

- Баяжуулагч бэлдмэлийн нэр, цувралын дугаар
- Зөвшөөрөгдөх дээд ба доод хэмжээнээс хэтэрсэн аливаа үзүүлэлт

7 Хадгалалт, тээвэрлэлт

7.1 Баяжуулагч бэлдмэлийг үйлдвэрлэгчийн өгсөн зааврын дагуу хортон, шавж, мэрэгчээр бохирдоогүй, гадны өвөрмөц үнэргүй, шороо, чийгээс бүрэн хамгаалсан агуулахад хадгална. Баяжуулагч бэлдмэлийг 60 %-аас ихгүй агаарын харьцангуй чийглэгтэй агуулахад 20 °С-ээс ихгүй температурт нарны шууд тусгалаас хамгаалж хадгална.

7.2 Баяжуулагч бэлдмэлийг энэ стандартын 7.1-д заасан шаардлагыг хангасан нөхцөлд 18 сар хүртэл хугацаанд хадгална.

7.3 Баяжуулагч бэлдмэлийг "MNS CAC/RCP 1:2003, Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим (олон улсын зөвлөмж)" стандартын хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

ТӨГСӨВ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын
2020 оны А-27 тоот тушаалын хавсралт

**БАЯЖУУЛСАН ХҮНС БОЛОХЫГ ИЛЭРХИЙЛСЭН ТЭМДЭГ,
ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ ЗАГВАР ХЭРЭГЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Баяжуулсан хүнс болохыг илэрхийлсэн тэмдэгийн загварыг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Монгол Улсын Засгийн газраас баталсан Албан журмаар баяжуулах хүнсний жагсаалтад орсон хүнсний бүтээгдэхүүнд энэхүү журам хамаарна.

**Хоёр. Баяжуулсан хүнс болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээг
хэрэглэхэд тавигдах шаардлага**

2.1. Баяжуулсан хүнс болохыг илэрхийлсэн тэмдэг нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу бүртгэгдсэн байна.

2.2. Баяжуулсан хүнс болохыг илэрхийлсэн тэмдэгийг www.mofa.gov.mn цахим хуудасаас татан авч, хэрэглэнэ.

2.3. Албан журмаар баяжуулсан хүнсний үйлдвэрлэл эрхлэгч нь зөвхөн баяжуулсан бүтээгдэхүүний шошгод баяжуулсан болохыг илэрхийлсэн тэмдэгийг хэрэглэнэ.

2.4. Албан журмаар баяжуулсан хүнс үйлвэрлэгч нь *Зураг 1* бүхий тэмдэгийг хэрэглэнэ.

Зураг 1.



2.5. Албан журмаар баяжуулах хүнсний жагсаалтад орсон хүнс импортлогч нь *Зураг1* бүхий тэмдэгийг хэрэглэнэ.

2.6. Албан журмаар баяжуулсан хүнс үйлдвэрлэгч, албан журмаар баяжуулах хүнсний жагсаалтад орсон хүнс импортлогч нь *Зураг1* бүхий тэмдэгийг сав, баглаа, боодлын зүүн дээд буланд байрлуулна.

2.7. Шошгоны орцын хэсэгт “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хуулийн 12 дахь хэсэгт заасны дагуу мэдээлэх бөгөөд баяжуулагч бэлдмэлийн орц найрлагыг бичнэ.

2.8. Баяжуулсан хүнс тэмдэгийг бүтээгдэхүүний савлагааны хэмжээнээс хамааруулан томруулах буюу багасган хэрэглэж болно.

2.9. Шошгоны нүүр хэсэгт бүтээгдэхүүний оноосон нэрийн өмнө, хойно “Баяжуулсан” гэсэн үгийг хэрэглэхийг хориглоно.

2.10. Хүнсний бүтээгдэхүүн сав боодлын шошгололтод тавих шаардлага MNS CAS 1:2007 стандартад заасны дагуу байна.

Гурав. Хариуцлага

3.1. Журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээд Зөрчлийн тухай хуульд болон бусад хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---ooOoo---

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 12 дүгээр сарын 30-ны өдрийн А/515 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт

Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө,

шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг бүртгэх,

нийтийн хэрэгцээнд гаргах журам

Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмаар баяжуулагч бэлдмэл¹, хүнсний нэмэлт², өсгөврийн хөрөнгө³, шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг⁴ улсын бүртгэлд бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргахтай холбоотой үүсэх харилцааг зохицуулна.

1.2 Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам) нь баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг импортлох, үйлдвэрлэхээс өмнө хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчээс цаасан болон цахим (бүртгэл, мэдээллийн сан)-аар ирүүлсэн хүсэлт, холбогдох бичиг баримтыг үндэслэн бүртгэн, дугаар олгох, нийтийн хэрэгцээнд гаргах удирдлага, зохион байгуулалтын эрхийг хэрэгжүүлнэ.

1.3. Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг улсын бүртгэлд бүртгэсэн эсэх шийдвэр нь Хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаал байна.

2.Баяжуулагч бэлдмэлийг бүртгэх

2.1. Албан журмаар баяжуулах хүнсний жагсаалтад заасан баяжуулагч бэлдмэлийг дараах бичиг баримтыг үндэслэн бүртгэж, дугаар олгоно. Үүнд:

2.1.1. хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн албан хүсэлт, энэ журмын хоёрдугаар хавсралтад заасан маягтын дагуу цаасан болон цахим хэлбэрээр ирүүлсэн өргөдөл,

2.1.2. баяжуулагч бэлдмэлийн гарал үүслийн гэрчилгээний хуулбар,

2.1.3. баяжуулагч бэлдмэлийн чанар, аюулгүй байдлын баталгаажуулалтын гэрчилгээний хуулбар,

2.1.4. итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн.

2.2. Хүнсийг сайн дураар баяжуулахад ашиглах баяжуулагч бэлдмэлийг энэ журмын 2.1 дэх хэсэгт заасан баримт бичгээс гадна нийгмийн эрүүл мэндийн эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын судалгааны тайлангийн үр дүн, зөвлөмж болон Хүнсний аюулгүй байдлын Үндэсний лавлагаа лабораторийн эрсдлийн үнэлгээний багийн зөвлөмжийг тус тус үндэслэн бүртгэж, дугаар олгоно.

1. “Баяжуулагч бэлдмэл” гэж Баяжуулсан хүнсний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дэх,
2. “Хүнсний нэмэлт” гэж Хүнсний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9 дэх,
3. “Өсгөврийн хөрөнгө” гэж мөн хуулийн 3.1.10 дахь,
4. “Шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнс” (цаашид “шинэ хүнс” гэх) гэж Хүнсний тухай хуулийн 3.1.8 дэх заалтад зааснаар тус тус ойлгоно.

2.3. Албан журмаар баяжуулах хүнсний баяжуулагч бэлдмэлийн бүртгэлийн дугаар нь ББА (баяжуулагч бэлдмэл албан журмын), сайн дураар баяжуулах хүнсний баяжуулагч бэлдмэлийн бүртгэлийн дугаар нь ББС (баяжуулагч бэлдмэл сайн дурын) гэж товчилсон том 3 үсэг болон бүртгэсэн он (бүртгэсэн оны сүүлийн 2 цифр), бүртгэлийн дугаар бүхий 4 оронтой тоо бүхий нийт 9 тэмдэгтээс тус тус бүрдэнэ. Жишээ нь:ББА190001, ББС190001

3. Хүнсний нэмэлтийг бүртгэх

3.1. Бүртгүүлэх хүнсний нэмэлт нь Хүнсний хууль эрх зүйн хорооны “Codex stan 192-1995, “Хүнсний нэмэлтийн ерөнхий стандарт”-ын “Хүнсний бүтээгдэхүүнд хэрэглэхийг зөвшөөрсөн хүнсний нэмэлтийн жагсаалт” болон Европын холбооны хүнсний нэмэлтийн жагсаалтад тус тус багтсан тохиолдолд дараах бичиг баримтыг үндэслэн бүртгэж, дугаар олгоно. Үүнд:

3.1.1. хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн албан хүсэлт, энэ журмын хоёрдугаар хавсралтад заасан маягтын дагуу цаасан болон цахим хэлбэрээр ирүүлсэн өргөдөл,

3.1.2. уг бүтээгдэхүүний тухайн орны гарал үүслийн гэрчилгээний хуулбар

3.1.3. бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын баталгаажуулалтын гэрчилгээний хуулбар,

3.1.4. итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн

3.2. Бүртгүүлэх хүнсний нэмэлт нь дээр дурдсан жагсаалтад заагдаагүй бол энэ журмын 3.1 дэх хэсэгт заасан баримт бичгээс гадна Хүнсний аюулгүй байдлын Үндэсний лавлагаа лабораторийн эрсдлийн үнэлгээний багийн зөвлөмжийг үндэслэн бүртгэж, дугаар олгоно.

3.3. Хүнсний нэмэлтийн бүртгэлийн дугаар нь хүнсний нэмэлт гэсэн (ХН) товчилсон үсэг, Олон улсын тоон систем (INS)-ийн тухайн нэмэлтийн ангилалд харгалзах дугаар (4 хүртэлх оронтой цифр), бүртгэсэн он (бүртгэсэн оны сүүлийн 2 цифр), бүртгэлийн дугаараас бүрдсэн 12 тэмдэгт бүхий байна. Жишээ нь: INS 300 (E 300) дугаартай аскорбины хүчлийн бүртгэлийн дугаар нь ХН 030019001 гэх мэт.

4.Өсгөврийн хөрөнгийг бүртгэх

4.1. Дотоодод үйлдвэрлэсэн болон импортын өсгөврийн хөрөнгийг бүртгэхдээ дараах бичиг баримтыг үндэслэн бүртгэж, дугаар олгоно. Үүнд:

4.1.1. хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн албан хүсэлт, энэхүү журмын хоёрдугаар хавсралтын дагуу ирүүлсэн өргөдөл,

4.1.2. өсгөврийн хөрөнгийн гарал үүслийн гэрчилгээний хуулбар,

4.1.3. өсгөврийн хөрөнгийн чанар, аюулгүй байдлын баталгаажуулалтын гэрчилгээний хуулбар,

4.1.4. өсгөврийн хөрөнгийн түүхий эд, бүтээгдэхүүний орц, найрлагын хувь хэмжээг тогтоосон тухай тэмдэглэл.

4.1.5 олон улсын стандартчиллын байгууллагаас тухайн өсгөврийн хөрөнгөний үйлдвэрлэлд олгосон хүчин төгөлдөр баталгаажуулалтын гэрчилгээний хуулбар /импортын өсгөврийн хөрөнгөнд хамаарна/

4.2. Өсгөврийн хөрөнгөний бүртгэлийн дугаар нь ИӨХ (импортын өсгөврийн хөрөнгө), ДӨХ (дотоодын өсгөврийн хөрөнгө) гэж товчилсон үг, эхний 2 тоо нь тухайн бүтээгдэхүүнийг бүртгэсэн он (бүртгэсэн оны сүүлийн 2 цифр), 3 оронтой тоо бүхий бүртгэлийн дугаараас бүрдсэн нийт 8 тэмдэгт байна. Жишээ нь: ИӨХ19001, ДӨХ19001

5. Шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг бүртгэх

5.1. Шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг улсын бүртгэлд бүртгүүлэхдээ дараах баримт бичгийн үндэслэн бүртгэж, дугаар олгоно.

5.1.1. хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн энэхүү журмын хоёрдугаар хавсралтын дагуу ирүүлсэн өргөдөл, албан хүсэлт,

5.1.2. “Шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний хүнсний эрсдэлийн үнэлгээ хийх журам”-д заасан эрх бүхий байгууллагын дүгнэлт,

5.1.3. Шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсээр бүртгэн, хуулийн дагуу эрхийн хамгаалалт хийгдсэнийг нотлох оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас олгосон гэрчилгээний хуулбар.

5.2. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шаардлагатай тохиолдолд тухайн шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний талаар дүгнэлт гаргах мэргэжлийн ажлын хэсгийг томилон ажиллуулж, энэ журмын 7.1-д заасан хугацааг ажлын 14 хоногоор сунгаж болно.

5.3. Шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний бүртгэлийн дугаар шинэ хүнсний (ШХ) товчилсон үг, эхний 2 тоо нь тухайн бүтээгдэхүүнийг бүртгэсэн он (бүртгэсэн оны сүүлийн 2 цифр), 3 оронтой тоо бүхий бүртгэлийн дугаараас бүрдсэн нийт 7 тэмдэгт байна. Жишээ нь: ШХ19001

6. Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, шинэ хүнсийг нийтийн хэрэгцээнд гаргах

6.1. Энэ журмын 2 ба 3, 4, 5 дугаар бүлэгт тус тус заасан бүртгэлийн дугаартай баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүнийг хүнсний сүлжээнд ашиглан, нийтийн хэрэгцээнд нийлүүлнэ.

6.2. Нийтийн хэрэгцээнд нийлүүлж буй баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний шошго нь MNS 6648:2016, “Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлын шошгололтод тавих шаардлага” стандартын шаардлагыг хангасан байна.

6.3. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг энэ журмын хавсралт -д заасан маягтын дагуу хөтөлж, тайланг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор яаманд ирүүлнэ.

7. Бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх

7.1. Яам нь хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн цаасаар болон цахимаар ирүүлсэн хүсэлтийг судлан үзээд, бүртгэсэн эсэх шийдвэрийг ажлын 10 хоногт багтаан хүсэлт ирүүлсэн албан байгууллагад хүргүүлнэ.

7.2. Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөвөр хөрөнгө, шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний бүртгэлийн мэдээллийг цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

7.3. Бүртгүүлэхээр ирүүлсэн баримт бичиг, мэдээллийн үнэн, зөв байдлыг бүртгүүлэгч этгээд бүрэн хариуцна.

8. Бүртгэлийг хүчингүй болгох, түдгэлзүүлэх

8.1. Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний бүртгэлийг дараах тохиодолд хүчингүй болгоно. Үүнд:

8.1.1. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг бүртгэлээс хасуулах тухай үндэслэл бүхий /үйлдвэрлэлийн технологи ажиллагаа, бүтээгдэхүүний орц, жор нь өөрчлөгдсөн гэх мэт/ хүсэлт гаргах;

8.1.2. Хүнсний нэмэлт нь Хүнсний хууль эрх зүйн хорооноос баталсан, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “Codex stan 192-1995, “Хүнсний нэмэлтийн ерөнхий стандарт”-ын “Хүнсний бүтээгдэхүүнд хэрэглэхийг зөвшөөрсөн хүнсний нэмэлтийн жагсаалт” болон Европын холбооны хүнсний нэмэлтийн жагсаалтаас хасагдсан;

8.1.3. Хүнсний аюулгүй байдлын Үндэсний лавлагаа лабораторийн эрсдлийн үнэлгээний баг баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний бүртгэлийг хүчингүй болгох тухай санал ирүүлсэн;

8.1.4. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12.4 дах заалтын дагуу хүнсний хяналтын улсын ахлах байцаагчийн гаргасан дүгнэлт ирүүлсэн;

8.1.5. Шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний эрсдэлийн үнэлгээ хийх журамд дурдсан эрх бүхий байгууллагаас санал гаргасан;

8.1.6. Шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний үйлдвэрлэл нь оюуны өмчийн эрхийн хууль тогтоомж зөрчсөн талаар оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас санал гаргасан;

8.2. Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний бүртгэлийг хүчингүй болгосон тухай шийдвэрийг ажлын 5 хоногт багтаан яамны цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

8.3. Яам энэ журмын 2 ба 3, 4, 5, 6 дугаар бүлэгт заасан баримт бичгийн бүрдэл дутуу, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн тохиодолд бүртгэхээс татгалзана.

8.4. Энэ журмыг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн хуулийн 6.14 дүгээр зүйлийн 7-д заасны дагуу хариуцлага хүлээнэ.

...ooOoo...

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 12 дүгээр сарын 30- ний өдрийн

A/515 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт

Баяжуулагч бэлдмэлийг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл

Холбогдох дөрвөлжинг тэмдэглэх

Шинээр бүртгүүлэх

Бүртгэлээс хасах

I ХЭСЭГ	
ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ / импортлогчийн ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	
Байгууллагын нэр, хаяг, шуудангийн хаяг	
Утасны дугаар	
Факсын дугаар	
Вэб хаяг	
Е-мэйл хаяг	
Харилцах албан тушаалтны овог нэр, утас, имэйл хаяг	
II ХЭСЭГ	
баяжуулагч бэлдмэлийн талаарх мэдээлэл	
Баяжуулагч бэлдмэлийн худалдааны нэршил	
Үйлдвэрлэсэн улс, байгууллагын нэр, хаяг, цахим хуудас	
Монгол улсад импортлосон байгууллагын нэр, хаяг, цахим хуудас	
Баяжуулагч бэлдмэлийн найрлага дахь бодисын нэр, хэмжээ /холимог нэгдэл бол/	
Нэр	Хэмжээ
1.	
2.	
3.	
Зориулалт	
Үйлдвэрлэлд хэрэглэх тун хэмжээ, хэрэглэх заавар, хадгалах нөхцөл	

Хүчинтэй хугацаа	
Бүтээгдэхүүний биет байдал	
Шошгын зураг	
Бүтээгдэхүүний сав баглаа боодлын зураг	

...ooOoo...

ХҮНСНИЙ НЭМЭЛТИЙГ УЛСЫН БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ

Холбогдох дөрвөлжинг тэмдэглэх

Шинээр бүртгүүлэх

Бүртгэлээс хасах

I ХЭСЭГ.	
ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ / ИМПОРТЛОГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	
Байгууллагын нэр, хаяг, шуудангийн хаяг	
Утасны дугаар	
Факсын дугаар	
Вэб хаяг	
Е-мэйл хаяг	
Харилцах албан тушаалтны овог нэр, утас, имэйл хаяг	
Хүнсний нэмэлтийг үйлдвэрлэсэн улс, байгууллагын нэр, хаяг, цахим хуудас	
Хүнсний нэмэлтийг Монгол улсад импортолсон байгууллагын нэр, хаяг, цахим хуудас	
II ХЭСЭГ.	
ХҮНСНИЙ НЭМЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	
Хүнсний нэмэлт бодисын нэр, олон улсын код /INS-ийн дугаар/	
Хүнсний нэмэлт бодисын зориулалт, хэрэглэх тун хэмжээ	
Хадгалах нөхцөл, заавар	
Хэрэглэх заавар	
Хүчинтэй хугацаа	
Бүтээгдэхүүний биет байдал	
Шошгын зураг	
Бүтээгдэхүүний сав баглаа боодлын зураг	

...ooOoo...

ДОТООДОД ҮЙЛДВЭРЛЭСЭН ӨСГӨВРИЙН ХӨРӨНГИЙГ

БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ

Холбогдох дөрвөлжинг тэмдэглэх

Шинээр бүртгүүлэх

Бүртгэлээс хасах

1. БҮРТГҮҮЛЭГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ				
Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн нэр				
Хаяг (цахим хаяг, холбоо барих утас, байршил)				
Харилцах ажилтны овог нэр, албан тушаал, утас, цахим шуудангийн хаяг				
2. ӨСГӨВРИЙН ХӨРӨНГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ				
Өсгөврийн хөрөнгийн оноосон нэр				
Бүтээгдэхүүний төлөв, гадаад байдал, хэмжээ, савлагаа, жин				
Шошгын зураг				
Бүтээгдэхүүний сав баглаа боодлын зураг				
Өсгөврийн хөрөнгийн орцын хувь хэмжээ, гр-аар	<10	11-50	51-99	100

...ooOoo..

**ИМПОРТЫН ӨСГӨВРИЙН ХӨРӨНГИЙГ
БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ**

Холбогдох дөрвөлжинг тэмдэглэх

Шинээр бүртгүүлэх

Бүртгэлээс хасах

1. ИМПОРТЛОГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ				
Байгууллагын нэр				
Хаяг (цахим шуудангийн хаяг байршил, утас)				
Бүртгэл хариуцсан ажилтны овог нэр, албан тушаал, утас, цахим шуудангийн хаяг				
2. ӨСГӨВРИЙН ХӨРӨНГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ				
Импортын өсгөврийн хөрөнгийн оноосон нэр				
Үйлдвэрлэгчийн нэр, хаяг, экспортлогч улсын эрх бүхий байгууллагаас олгосон чанар (тохирол)-ын гэрчилгээ, эрүүл ахуй (эрүүл мэнд)-н гэрчилгээ, гарал үүслийн гэрчилгээний хуулбар				
Бүтээгдэхүүний төлөв байдал, савлагаа, жин, гадаад байдал				
Шошгын зураг				
Бүтээгдэхүүний сав баглаа боодлын зураг				
Орцын хувь хэмжээ, гр-аар	<10	11-50	51-99	100

...ooOoo...

**ШИНЭ ТЕХНОЛОГИОР ҮЙЛДВЭРЛЭСЭН ХҮНСИЙГ БҮРТГҮҮЛЭХ
ХҮСЭЛТ**

Холбогдох дөрвөлжинг тэмдэглэх

Шинээр бүртгүүлэх

Бүртгэлээс хасах

1. БҮРТГҮҮЛЭГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	
Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн нэр	
Хаяг (цахим хаяг, холбоо барих утас, байршил)	
Харилцах ажилтны овог нэр, албан тушаал, утас, цахим шуудангийн хаяг	
2. ШИНЭ ХҮНСНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	
Шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний оноосон нэр	
Бүтээгдэхүүний төлөв, гадаад байдал, хэмжээ, савлагаа, жин	
Шошгын зураг	
Бүтээгдэхүүний сав баглаа боодлын зураг	
Хэрэглэх заавар	
Хадгалах нөхцөл	
Хүчинтэй хугацаа	

..... (байгууллагын нэр) нь Монгол Улсын шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний улсын бүртгэлд бүртгүүлэхээр бүрдүүлж өгсөн бичиг баримт үнэн болно.

..... гарын үсэг, тамга ... он ... сар ... өдөр

...ooOoo...

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын

2019 оны 12 дүгээр сарын 30-ний өдрийн А/515 дүгээр

тушаалын гуравдугаар хавсралт

Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгийн

ул мөрийг мөшгих бүртгэл

№ нэр, бүртгэлийн дугаар	Импортын тоо хэмжээ	Борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ		Үйлдвэрлэлд хүлээн авсан бүтээгдэхүүний тоо хэмжээ		Үйлдвэрлэлд ашигласан бүтээгдэхүүний тоо хэмжээ	Мэдээлэл ирүүлсэн байгууллага, албан тушаалтны нэр, холбоо барих утас
		Хаана, хэнд	Тоо хэмжээ	Хаанаас авсан	Тоо хэмжээ		
1							
2							
3							

...00000...